

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН 2018 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудитын тайлан.....	4
2.1. Оршил.....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	7
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	7
2.8.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	7
2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	8
2.11. Шилэн дансны мэдээлэл	8
2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	8
2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	8
3. Менежментийн захидал.....	9
3.1 Орлогын төлөвлөлт, гүйцэтгэлийн талаар	9
3.2 Үндсэн хөрөнгийн талаар	9
3.3 Санхүүгийн бүртгэл тайлагналын талаар.....	10
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	11
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	11
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	12
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	14
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	16
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	17
5. Аудитын явцад илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл.....	19

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

ХУУЛЬ САХИУЛАХЫН ИХ
СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН
АЛБАН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА
Б.БАТ-ЭРДЭНЭ ТАНАА

2019.02.25 № 06/303
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хууль сахиулахын их сургуулийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Хууль сахиулахын их сургуулийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Хууль сахиулахын их сургуулийн 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Хууль сахиулахын их сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг тус сургуулийн захирлын албан үүрэг гүйцэтгэгч Цагдаагийн хурандаа Б.Бат-Эрдэнэ танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн орлого, зардал, үндсэн хөрөнгийн бүртгэл тайлагналтай холбоотой зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1,18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хууль сахиулахын их сургуулийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хууль сахиулахын их сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 2 дугаар сарын 12-наас 2 дугаар сарын 23-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Санхүүгийн аудитын газрын аудитор С.Отгонхорлоо хариуцаж хэрэгжүүлэв.

Хууль сахиулахын их сургууль 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2019 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 01/174 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Хууль сахиулахын их сургуулийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Хууль сахиулахын их сургууль нь Хүний эрх, шударга ёс, хуулийг дээдэлж, ажил үйлчилгээндээ чанарыг эрхэмлэсэн хууль сахиулах салбарын сургалт, эрдэм шинжилгээ, судалгаа инновацийн хөгжлийн гол түшиц байгууллага болох зорилгын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлэн ажиллаж байна. Үүнд:

- Орчин үеийн их сургуулийн жишиг, нийгмийн хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн сургалтын хөтөлбөр, багшийн заах арга зүйг сайжруулах замаар сургалтын чанар, үр дүнг дээшлүүлж, захиалагчийн хэрэгцээ, шаардлагыг хангасан цогц чадамж бүхий мэргэжилтэн бэлтгэнэ.
- Эрдэм шинжилгээ, судалгааны ажлын тоо, чанар, практик үр өгөөжийг нэмэгдүүлж, салбарын шинжлэх ухаан, технологи, инновацийн дэд бүтцийг бий болгож, улс орны хөгжил дэвшилд хувь нэмэр оруулагч судалгааны их сургууль болно.
- Олон улсын жишиг, Их сургуулийн эрхэм зорилгод нийцсэн сургалт, судалгаа, туршилт-боловсруулалтын материаллаг бааз, багш, судлаач, суралцагчийн ажиллах, суралцах, бие даан хөгжих боломжийг хангасан орчин нөхцөлийг бүрдүүлнэ.
- Их сургуулийн мэдлэг оюуны чадавх, соёл, уламжлалыг тээгч багш, судлаач, ажилтан, суралцагчийг бүх талаар хөгжүүлэх бодлого хэрэгжүүлж, мэргэшсэн, хариуцлага, ёс зүйтэй, тэргүүний хамт олон, суралцагч байгууллага болно.
- Тогтвортой хөгжлийг дэмжсэн оновчтой бодлого хэрэгжүүлж, үр ашигтай хамтын ажиллагааг өргөжүүлж, Их сургуулийн гадаад, дотоод нэр хүнд, байр суурийг бэхжүүлнэ.

Үйл ажиллагааны чиглэл:

Хууль сахиулахын их сургуулийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хууль сахиулахын ажлын инновацийн үр ашигтай тогтолцоог хөгжүүлэх,
- Мэргэжлийн болон өндөр боловсрол, мэдлэгтэй, төрийн тусгай албаны шилмэл бүрэлдэхүүнийг бэлтгэх,
- Хууль сахиулахын салбарын эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг чанарын өндөр түвшинд гүйцэтгэх.

Эрх зүйн шинэтгэлийг гүнзгийрүүлж, Их сургуулийн эрх зүйн таатай орчныг бүрдүүлэх,

- Төрийн бодлого, шийдвэрийг хэрэгжүүлж, гүйцэтгэлийн удирдлагыг сайжруулах,
- Гадаад дотоодын сургалт, эрдэм шинжилгээний байгууллагуудын хамтын ажиллагааг өргөжүүлэх,
- Хууль зүйн салбарын инновацийн дэд бүтцийг хөгжүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх,
- Соён гэгээрүүлэх, байгууллагын соёлыг төлөвшүүлэх,
- Бие бүрэлдэхүүний ажиллаж, суралцах таатай орчин бүрдүүлэх, нийгмийн асуудлыг шийдвэрлэх.
- Хууль сахиулахын их сургуулийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд төлөвлөсөн хэмжээнд судалж, баримтжуулсан.

Хууль сахиулахын их сургуулийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Хууль сахиулахын их сургуулийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Цагдаагийн тухай хууль

Тайлант хугацаанд эрх зүйн орчны талаар томоохон өөрчлөлт гараагүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Хууль сахиулахын их сургуулийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Хууль сахиулахын их сургууль санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Acolous” програм хангамж ашигладаг байна.

Хууль сахиулахын их сургуулийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Хууль сахиулахын их сургуулийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 8 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 5 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны эхний хагас жилийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгосон. Гүйцэтгэлийн үе шатанд 2018 оны жилийн эцсийн Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1 хувь болох 140,048.2 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тогтоолоо.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 8 чиглэлээр аудитын 5 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 5 асуудлыг алдаа, зөрчилтөйд тооцож, 3 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэсэн ба аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийгдээгүй болно.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

№	Шийдэл	Тоо	Дүн	/мянган төгрөг/ Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	5	564,892.8	
	Дүн	5	564,892.8	

2.8.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлыг зөвлөмж өгөхөөр асуудлыг Менежментийн захидалд оруулсан бөгөөд, бусад хэлбэрээр шийдсэн алдаа байхгүй болно.

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц чухал асуудал илрээгүй болно.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Хууль сахиулахын их сургуулийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 6 хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 11,151,686.9 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 11,043,474.1 мянган төгрөг буюу 108,212.7 мянган төгрөгөөр хэмнэсэн байна.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Хууль сахиулахын их сургууль Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Шилэн дансны нэгдсэн мэдээллийн системд хуудсанд батлагдсан төсөв, гүйцэтгэлтэй холбоотой мэдээллүүд, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ, бусад мэдээллийг байрлуулсан байна.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар авч үзэхэд дараах байдалтай байна.

Хууль сахиулахын их сургуулийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар 3 зөвлөмж өгөгдсөн байна. Үүнээс 2 зөвлөмжийг бүрэн биелүүлж, 1 зөвлөмжийн хэрэгжилт 95,0 хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Хууль сахиулахын их сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Хууль сахиулахын их сургуулийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Хууль сахиулахын их сургуулийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Орлогын төлөвлөлт, гүйцэтгэлийн талаар

3.1.1 Илрүүлэлт:

Үндсэн үйл ажиллагааны орлогоос Улсын төсөвт 568,250.0 мянган төгрөг төвлөрүүлэх төлөвлөгөөтэйгөөс гүйцэтгэлээр 675.456.4 мянган төгрөг төвлөрүүлсэн. Улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг бодит тоо мэдээлэлд үндэслэн төлөвлөөгүйгээс орлогын төлөвлөгөө 55,5 хувиар давж биелсэн бөгөөд уг давсан орлогоос 356,241.3 мянган төгрөгийг Сангийн сайдын 224, 275 дугаар тушаалуудаар үйл ажиллагаандаа зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэснийг мөрдөж ажиллаагүй байна.

3.1.2 Эрсдэл:

Холбогдох хууль эрх зүйн актууд зөрчигдөх.

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг бодит тоо мэдээлэлд үндэслэн үнэн зөв төлөвлөх.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу:

Аудитаар илрүүлсэн асуудлын бүртгэлтэй танилцаж, баталгаажуулсан болно.

3.2 Үндсэн хөрөнгийн талаар

3.2.1 Илрүүлэлт:

Хандиваар авсан 206.490.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын шийдвэргүйгээр бүртгэж, тайлагнасан байна.

Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2017 оны 86 дугаар тушаалаар баталсан төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журмын 4 дүгээр зүйлийн 4.2-т "төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд нь, Улсын төсвийн хөрөнгө оруулалт, зээл, хандив, тусламж, бэлэглэл, өр төлбөрт тооцон хөрөнгө олж авбал тухай бүр Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт мэдэгдэж, уг хөрөнгийг холбогдох хууль тогтоомж, журамд заасны дагуу бүртгэлд тусгах зөвшөөрөл авна" гэснийг мөрдөж ажиллаагүй байна.

3.2.2 Эрсдэл:

Хөрөнгө бүртгэгдэхгүй байх.

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Хөрөнгийг бэлтгэхдээ холбогдох байгууллагаас зөвшөөрөл авч данс бүртгэлд тусгах.

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу:

Аудитаар илрүүлсэн асуудлын бүртгэлтэй танилцаж, баталгаажуулсан болно.

3.3 Санхүүгийн бүртгэл тайлагналын талаар

3.3.1 Илрүүлэлт

Шатахууны урамшуулал 2,161.5 мянган төгрөгийг бэлнээр хүлээн авсан боловч орлогоор бүртгэж, тайлагнаагүй.

Энэ нь "Үнэн зөв байх" батламж мэдэгдэл болон Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д "төсвийн орлого, зарлага, хөрөнгө, өр төлбөрийг бууруулах бичилт хийхгүйгээр нийт дүнгээр нь төлөвлөж, тайлагнах" гэсэнтэй нийцэхгүй байна.

3.3.2 Эрсдэл:

Санхүүгийн тайлагнал буруу илэрхийлэгдэх.

3.3.3 Өгсөн зөвлөмж:

Бүртгэл тайлагналыг үнэн зөв илэрхийлэх.

3.3.4 Байгууллагаас өгсөн хариу:

Аудитаар илрүүлсэн асуудлын бүртгэлтэй танилцаж, баталгаажуулсан болно.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2019 оны 06 дугаар сарын 30-ны дотор ирүүлэх.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлан хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

БАЛАНСЫН ҮЗҮҮЛЭЛТ	ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	2,190,534,667.10	2,379,849,380.21
МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	21,121.80	-
АВЛАГА	27,932,424.00	27,932,424.00
Бусад авлага	27,932,424.00	27,932,424.00
Байгууллагаас авах авлага	10,250,000.00	10,250,000.00
Хувь хүмүүсээс авах авлага	17,682,424.00	17,682,424.00
УРЬДЧИЛГАА	186,533,922.00	67,528,818.00
Урьдчилж гарсан зардал	186,533,922.00	67,528,818.00
БАРАА МАТЕРИАЛ	1,976,047,199.30	2,284,388,138.21
Түүхий эд материал	453,131,330.20	455,062,327.36
Тусгай зориулалттай материал	435,723,749.10	444,111,451.06
Эм боох материал	17,407,581.10	10,950,876.30
Бэлэн бүтээгдэхүүн	333,863,736.51	549,753,985.51
Хангамжийн материал	1,189,052,132.59	1,279,571,825.34
Бичиг хэргийн материал	79,308,602.84	97,442,776.90
Аж ахуйн материал	610,939,435.75	667,581,150.36
Сэлбэг хэрэгсэл	19,536,728.20	15,510,500.00
Түлш шатах тослох материал	9,651,654.25	2,884,663.25
Барилгын засварын материал	206,083,836.50	200,014,371.00
Хүнсний материал	162,793,889.65	173,073,549.83
Бусад хангамжийн материал	100,737,985.40	123,064,814.00
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	45,574,339,042.56	66,317,275,059.92
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	45,574,339,042.56	66,317,275,059.92
Биет хөрөнгө	45,558,089,667.63	52,068,652,886.02
Барилга, байгууламж	47,869,638,631.90	49,960,361,270.50
Хуримтлагдсан элэгдэл	(5,695,816,619.28)	(2,180,015,447.32)
Авто тээврийн хэрэгсэл	716,670,532.00	718,350,532.00
Хуримтлагдсан элэгдэл	(605,558,755.62)	(1,266,315,346.61)
Машин, тоног төхөөрөмж	1,965,818,769.47	2,347,257,883.00
Хуримтлагдсан элэгдэл	(1,237,412,658.54)	(1,451,798,609.77)
Тавилга, аж ахуйн эд хогшил	2,083,751,928.60	2,258,566,353.60
Хуримтлагдсан элэгдэл	(735,973,199.94)	(935,157,498.06)
Батлан хамгаалахын зориулалттай тоног төхөөрөмж	311,157,936.00	353,009,130.00
Хуримтлагдсан элэгдэл	(22,736,286.00)	(22,736,286.00)
Бусад үндсэн хөрөнгө	494,398,518.35	1,130,991,015.35
Хуримтлагдсан элэгдэл	(156,368,337.16)	(76,587,742.14)
Номын фонд	570,519,207.85	627,168,875.85
Биет бус хөрөнгө	16,249,374.93	14,248,622,173.90
Програм хангамж	55,664,060.00	56,118,605.50
Хасагдуулга	(39,414,685.07)	(47,779,211.60)
Газар эзэмших эрх	-	14,240,282,780.00
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	47,764,873,709.66	68,697,124,440.13
НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	0.00	0.00
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.00	0.00
ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	47,764,873,709.66	68,697,124,440.13
Засгийн газрын хувь оролцоо	47,764,873,709.66	68,697,124,440.13
Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/ орон нутгийн сан	5,588,860,843.91	20,395,129,927.91
Өмч: -Төрийн өмч	5,588,860,843.91	20,395,129,927.91
Хуримтлагдсан үр дүн	37,070,904,378.25	36,392,181,855.60
Өмнөх үеийн үр дүн	37,070,904,378.25	37,070,904,378.25
Тайлант үеийн үр дүн	-	(678,722,522.65)
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	5,105,108,487.50	11,909,812,656.62
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	47,764,873,709.66	68,697,124,440.13

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлан хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

БАЛАНСЫН ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОНЫ ГҮЙЦЭТГЭЛ	ТАЙЛАНТ ОНЫ ГҮЙЦЭТГЭЛ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	11,823,681,961.08	13,326,101,390.79
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,273,165,861.08	1,019,762,696.79
Нийтлэг татварын бус орлого	1,273,165,861.08	675,465,402.00
Төсөвт байгууллагын өөрийн орлого	1,273,165,861.08	675,465,402.00
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	740,378,380.00	656,991,676.00
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	211,728,639.00	18,473,726.00
Үнэ төлбөргүй ирсэн материал	12,694,084.00	-
Үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгө	308,364,758.08	-
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	-	344,297,294.79
Хандив тусламж /дотоод/	-	344,297,294.79
САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	10,550,516,100.00	12,306,338,694.00
Улсын төвлөрсөн төсвөөс	10,536,201,100.00	11,215,286,900.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	10,536,201,100.00	11,151,686,900.00
Хөрөнгийн санхүүжилт	-	63,600,000.00
Нэмэлт санхүүжилтийн орлого	14,315,000.00	1,091,051,794.00
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж	5,040,000.00	428,253,370.00
ЗГНХ, Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөнөөс	-	4,500,000.00
Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагч	9,275,000.00	266,957,100.00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	391,341,324.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	11,874,032,112.36	13,485,481,490.05
УРСГАЛ ЗАРДАЛ	11,874,032,112.36	13,485,481,490.05
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	11,133,076,723.99	12,323,312,279.70
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	6,158,244,706.00	6,595,127,734.00
Цалин	4,109,778,768.00	3,957,643,674.00
Нэмэгдэл цалин	1,836,373,938.00	2,407,548,860.00
Унаа хоолны хөнгөлөлт	212,092,000.00	229,935,200.00
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	179,793,110.00	199,809,050.00
Тэтгэврийн даатгалын шимтгэл	32,145,900.00	54,301,700.00
Тэтгэмжийн даатгалын шимтгэл	4,592,200.00	4,592,200.00
ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	3,673,900.00	3,673,900.00
Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	918,400.00	918,400.00
Эрүүл мэндийн даатгалын хураамж	138,462,710.00	136,322,850.00
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	560,364,297.04	620,373,493.00
Гэрэл цахилгааны зардал	257,592,237.00	281,335,978.00
Түлш, халаалтын зардал	214,913,121.22	251,124,034.00
Цэвэр, бохир усны зардал	87,858,938.82	87,913,481.00
Хангамж, бараа материалын зардал	268,792,151.77	321,780,170.34
Бичиг хэргийн материал	105,535,438.85	107,759,857.74
Тээвэр, шатахууны зардал	74,873,851.00	83,103,241.00
Шуудан холбоо интернетийн төлбөр	24,229,425.77	27,731,800.00
Ном, хэвлэлийн зардал	18,611,560.00	15,071,805.00

Хууль сахиулахын их сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Бага үнэ түргэн элэгдэл зүйлс	26,503,998.15	46,195,189.60
Бараа материал акталсны зардал	19,037,878.00	41,918,277.00
Нормативт зардал	1,668,522,363.73	1,638,790,103.16
Эм	21,564,938.90	43,964,244.80
Хоол	873,942,726.33	913,166,161.73
Нормын хувцас, зөөлөн эдлэл	773,014,698.50	681,659,696.63
Эд хогшил, урсгал засварын зардал	273,367,685.60	290,214,307.70
Багаж хэрэгсэл	359,900.00	168,000.00
Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	12,430,575.80	3,311,780.00
Урсгал засвар	260,577,209.80	286,734,527.70
Томилолт, зочны зардал	22,047,196.00	63,502,800.00
Дотоод томилолтын зардал	22,047,196.00	46,029,800.00
Зочин төлөөлөгч хүлээн авах	-	17,473,000.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	129,157,357.02	566,925,404.80
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	106,887,069.02	521,321,616.00
Даатгалын үйлчилгээний төлбөр	9,023,188.00	12,140,625.00
Тээврийн хэрэгслийн татвар	2,725,700.00	3,059,400.00
Тээврийн хэрэгслийн оношилгоо	290,300.00	850,042.00
Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс	10,195,400.00	29,532,600.00
Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	35,700.00	21,121.80
Бараа үйлчилгээний бусад зардал	1,872,787,856.83	2,026,789,216.70
Бараа үйлчилгээний бусад зардал	19,084,300.00	33,941,300.00
Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	300,403,288.00	461,624,688.00
Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	1,553,300,268.83	1,531,223,228.70
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	740,955,388.37	1,162,169,210.35
Бусад урсгал шилжүүлэг	692,996,282.20	1,053,956,465.40
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	160,812,106.40	201,032,023.40
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	364,719,992.00	852,848,182.00
Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	167,464,183.80	76,260.00
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	47,959,106.17	108,212,744.95
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	47,959,106.17	-
Төвлөрүүлэх шилжүүлэг	-	108,212,744.95
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	(50,350,151.28)	(159,380,099.26)
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)	12,312,500.12	519,342,423.39
Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	12,312,500.12	516,158,372.53
Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	-	3,184,050.86
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VI=IV-V)	(12,312,500.12)	(519,342,423.39)
НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI)	(62,662,651.40)	(678,722,522.65)

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлан хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

БАЛАНСЫН ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОНЫ ҮЛДЭГДЭЛ	ТАЙЛАНТ ОНЫ ҮЛДЭГДЭЛ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	11,438,664,194.00	12,981,804,096.00
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	888,148,094.00	675,465,402.00
Нийтлэг татварын бус орлого	888,148,094.00	675,465,402.00
Төсөвт байгууллагын өөрийн орлого	888,148,094.00	675,465,402.00
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	740,378,380.00	656,991,676.00
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	147,769,714.00	18,473,726.00
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	10,550,516,100.00	12,306,338,694.00
Улсын төвлөрсөн төсвөөс	10,536,201,100.00	11,215,286,900.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	10,536,201,100.00	11,151,686,900.00
Хөрөнгийн санхүүжилт	-	63,600,000.00
Нэмэлт санхүүжилтийн орлого	14,315,000.00	1,091,051,794.00
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж	5,040,000.00	428,253,370.00
ЗГНХ, ЗДНХөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөнөөс	-	4,500,000.00
Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагч	9,275,000.00	266,957,100.00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	391,341,324.00
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	10,778,464,974.00	12,158,925,320.30
УРСГАЛ ЗАРДАЛ	10,778,464,974.00	12,158,925,320.30
БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	9,911,450,805.83	11,061,029,993.35
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	6,158,244,706.00	6,595,127,734.00
Үндсэн цалин	4,058,730,906.00	3,957,643,674.00
Нэмэгдэл	1,864,725,400.00	2,407,548,860.00
Унаа хоолны хөнгөлөлт	234,788,400.00	229,935,200.00
Ажил ологчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	179,793,110.00	199,809,050.00
Тэтгэврийн даатгалын шимтгэл	32,145,900.00	54,301,700.00
Тэтгэмжийн даатгалын шимтгэл	4,592,200.00	4,592,200.00
ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	3,673,900.00	3,673,900.00
Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	918,400.00	918,400.00
Эрүүл мэндийн даатгалын хураамж	138,462,710.00	136,322,850.00
Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал	567,007,967.04	620,373,493.00
Гэрэл цахилгааны зардал	257,592,237.00	281,335,978.00
Түлш, халаалтын зардал	214,913,121.22	251,124,034.00
Цэвэр, бохир усны зардал	94,502,608.82	87,913,481.00
Хангамж, бараа материалын зардал	167,627,998.77	192,501,469.80
Бичиг хэрэг	22,643,480.00	21,018,620.80
Тээвэр, шатахуун	68,616,125.00	79,309,750.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	24,229,425.77	27,731,800.00
Ном, хэвлэл	19,299,560.00	15,112,405.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	32,839,408.00	49,328,894.00
Нормативт зардал	1,738,835,293.50	1,882,514,211.54
Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	35,353,400.00	40,537,390.00
Хоол, хүнс	827,817,497.00	923,445,821.91
Нормын хувцас, зөөлөн эдлэл	875,664,396.50	918,530,999.63
Эд хогшил, урсгал засварын зардал	468,897,172.50	263,502,774.00
Багаж техник хэрэгсэл	38,608,782.00	3,523,940.00

Хууль сахиулахын их сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	57,541,473.00	11,329,100.00
Урсгал засвар	372,746,917.50	248,649,734.00
Томилолт, зочны зардал	22,047,196.00	63,502,800.00
Дотоод албан томилолт	22,047,196.00	46,029,800.00
Зочин төлөөлөгч хүлээн авах	-	17,473,000.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	178,767,746.02	590,508,080.01
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж	118,409,208.02	526,969,516.00
Даатгалын үйлчилгээ	9,023,188.00	12,140,625.00
Тээврийн хэрэгслийн татвар	2,725,700.00	3,059,400.00
Тээврийн хэрэгслийн оношлогоо	290,300.00	850,042.00
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	48,283,650.00	47,467,375.21
Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	35,700.00	21,121.80
Бараа үйлчилгээний бусад зардал	430,229,616.00	653,190,381.00
Бараа үйлчилгээний бусад зардал	19,622,900.00	68,389,800.00
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	410,606,716.00	584,800,581.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	867,014,168.17	1,097,895,326.95
Бусад урсгал шилжүүлэг	819,055,062.00	989,682,582.00
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	156,875,980.00	219,464,672.00
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	514,879,082.00	770,217,910.00
Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	147,300,000.00	-
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	47,959,106.17	108,212,744.95
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	47,959,106.17	-
Төвлөрүүлэх шилжүүлэг	-	108,212,744.95
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	660,199,220.00	822,878,775.70
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	660,199,920.00	822,899,897.50
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	660,199,920.00	822,899,897.50
Дотоод эх үүсвэрээр	660,199,920.00	822,899,897.50
Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	660,199,920.00	822,899,897.50
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(660,199,920.00)	(822,899,897.50)
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(700.00)	(21,121.80)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	21,821.80	21,121.80
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	21,121.80	-

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлан хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2017 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл	5,588,860,843.91	5,105,108,487.50	14,495,254,231.93	25,189,223,563.34
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,588,860,843.91	5,105,108,487.50	14,495,254,231.93	25,189,223,563.34
Дахин үнэлгээний нэмэгдэл, хэрэгжсэн дүн				
Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний гарз				
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз				
Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/			17,402,249,302.26	17,402,249,302.26
2017 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл				
2017 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	5,588,860,843.91	5,105,108,487.50	37,070,904,378.25	47,764,873,709.66
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,588,860,843.91	5,105,108,487.50	37,070,904,378.25	47,764,873,709.66
Дахин үнэлгээний нэмэгдэл, хэрэгжсэн дүн		6,804,704,169.12		6,804,704,169.12
Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний гарз				
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз				
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				
Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/	14,806,269,084.00		(678,722,522.65)	14,127,546,561.35
2018 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	20,395,129,927.91	11,909,812,656.62	36,392,181,855.60	68,697,124,440.13

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлан хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

БАЛАНСЫН ҮЗҮҮЛЭЛТ	БАТЛАГДСАН ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	ЗӨРҮҮ	Хувь
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	21,121.80	(21,121.80)	-
I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	11,725,836,900.00	12,809,991,351.05	(1,084,154,451.05)	109.25
УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	11,725,836,900.00	12,809,991,351.05	(1,084,154,451.05)	109.25
Бараа, үйлчилгээний зардал	10,839,317,700.00	11,820,308,769.05	(980,991,069.05)	109.05
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	6,546,393,700.00	6,595,127,734.00	(48,734,034.00)	100.74
Үндсэн цалин	3,961,969,600.00	3,957,643,674.00	4,325,926.00	99.89
Нэмэгдэл	2,354,488,900.00	2,407,548,860.00	(53,059,960.00)	102.25
Унаа, болон бусад нөхөн олговор	229,935,200.00	229,935,200.00	-	100.00
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	200,017,600.00	199,809,050.00	208,550.00	99.90
Тэтгэврийн даатгал	54,301,700.00	54,301,700.00	-	100.00
Тэтгэмжийн даатгал	4,592,200.00	4,592,200.00	-	100.00
ҮОМШӨ ний даатгал	3,673,900.00	3,673,900.00	-	100.00
Ажилгүйдлийн даатгал	918,400.00	918,400.00	-	100.00
Эрүүл мэндийн даатгал	136,531,400.00	136,322,850.00	208,550.00	99.85
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	567,060,000.00	620,373,493.00	(53,313,493.00)	109.40
Гэрэл цахилгаан	253,122,400.00	281,335,978.00	(28,213,578.00)	111.15
Түлш, халаалт	226,538,600.00	251,124,034.00	(24,585,434.00)	110.85
Цэвэр, бохир ус	87,399,000.00	87,913,481.00	(514,481.00)	100.59
Хангамж, бараа материалын зардал	233,123,900.00	236,692,064.80	(3,568,164.80)	101.53
Бичиг хэрэг	19,843,800.00	21,018,620.80	(1,174,820.80)	105.92
Тээвэр (шатахуун)	79,310,000.00	79,309,750.00	250.00	100.00
Шуудан холбоо, интернэтийн төлбөр	27,731,800.00	27,731,800.00	-	100.00
Ном, хэвлэл	59,303,000.00	59,303,000.00	-	100.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	46,935,300.00	49,328,894.00	(2,393,594.00)	105.10
Нормативт зардал	1,796,776,700.00	1,882,514,211.54	(85,737,511.54)	104.77
Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	40,537,400.00	40,537,390.00	10.00	100.00
Хоол, хүнс	837,708,300.00	923,445,821.91	(85,737,521.91)	110.23
Нормын хувцас зөөлөн эдлэл	918,531,000.00	918,530,999.63	0.37	100.00
Эд хогшил худалдан авах	645,529,600.00	859,179,598.60	(213,649,998.60)	133.10
Багаж, техник, хэрэгсэл	205,488,100.00	226,228,600.00	(20,740,500.00)	110.09
Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	119,116,700.00	182,476,800.00	(63,360,100.00)	153.19
Урсгал засвар	320,924,800.00	450,474,198.60	(129,549,398.60)	140.37
Томилолт, зочны зардал	63,502,800.00	63,502,800.00	-	100.00
Дотоод албан томилолт	46,029,800.00	46,029,800.00	-	100.00
Зочин төлөөлөгч хүлээн авах	17,473,000.00	17,473,000.00	-	100.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	143,985,600.00	632,399,446.11	(488,413,846.11)	439.21
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	39,862,400.00	528,369,516.00	(488,507,116.00)	1,325.48
Даатгалын үйлчилгээ	12,201,100.00	12,140,625.00	60,475.00	99.50
Тээврийн хэрэгслийн татвар	3,059,400.00	3,059,400.00	-	100.00
Тээврийн хэрэгслийн оношилгоо	869,000.00	850,042.00	18,958.00	97.82
Мэдээллийн технологийн зардал	87,993,700.00	87,979,863.11	13,836.89	99.98

Хууль сахиулахын их сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Бараа үйлчилгээний бусад зардал	642,927,800.00	730,710,371.00	(87,782,571.00)	113.65
Бараа үйлчилгээний бусад зардал	136,360,000.00	136,189,800.00	170,200.00	99.88
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	506,567,800.00	594,520,571.00	(87,952,771.00)	117.36
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	886,519,200.00	989,682,582.00	(103,163,382.00)	111.64
Бусад урсгал шилжүүлэг	886,519,200.00	989,682,582.00	(103,163,382.00)	111.64
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	116,301,200.00	219,464,672.00	(103,163,472.00)	188.70
Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	770,218,000.00	770,217,910.00	90.00	100.00
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	63,600,000.00	63,600,000.00	-	100.00
Тоног төхөөрөмж	63,600,000.00	63,600,000.00	-	100.00
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	11,725,836,900.00	12,809,991,351.05	(1,084,154,451.05)	109.25
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	11,151,686,900.00	11,043,474,155.05	108,212,744.95	99.03
Улсын төсвөөс санхүүжих	11,151,686,900.00	11,043,474,155.05	108,212,744.95	99.03
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	574,150,000.00	675,465,402.00	(101,315,402.00)	117.65
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	568,250,000.00	656,991,676.00	(88,741,676.00)	115.62
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,900,000.00	18,473,726.00	(12,573,726.00)	313.11
Нэмэлт санхүүжилтийн орлого	-	1,091,051,794.00	(1,091,051,794.00)	-
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	428,253,370.00	(428,253,370.00)	-
ЗГНХ, Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс зохих байгууллагын шийдвэрийн дагуу тухай төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	4,500,000.00	(4,500,000.00)	-
Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	266,957,100.00	(266,957,100.00)	-
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	391,341,324.00	(391,341,324.00)	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	21,121.80	(21,121.80)	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	-

5. Аудитын явцад илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	2018 он	Аудитын нэр:	Санхүүгийн тайлангийн аудит	САГ-2019/320/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Хууль сахиулахын их сургууль		мянган төгрөгөөр	

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
А	1	2	3	4	5
1	Үндсэн үйл ажиллагааны орлогоос Улсын төсөвт 568,250.0 мянган төгрөг төвлөрүүлэх төлөвлөгөөтэйгөөс гүйцэтгэлээр 675.456.4 мянган төгрөг төвлөрүүлсэн. Улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг бодит тоо мэдээлэлд үндэслэн төлөвлөөгүйгээс орлогын төлөвлөгөө 55,5 хувиар давж биелсэн бөгөөд уг давсан орлогоос 356,241.3 мянган төгрөгийг Сангийн сайдын 224, 275 дугаар тушаалуудаар үйл ажиллагаандаа зарцуулсан байна.	356,241.3	Зөвлөмж хүргүүлэх	ХСИС-ийн захирал, Ерөнхий нягтлан бодогч	Ө.Энхтөр, Ц.Мөнгөнцэцэг
2	Хандиваар авсан 206.490.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын шийдвэргүйгээр бүртгэж, тайлагнасан байна.	206,490.0	Зөвлөмж хүргүүлэх	ХСИС-ийн захирал, Ерөнхий нягтлан бодогч	Ө.Энхтөр, Ц.Мөнгөнцэцэг
3	Шатахууны урамшуулал 2,161.5 мянган төгрөгийг бэлнээр хүлээн авсан боловч орлогоор бүртгэж, тайлагнаагүй.	2,161.5	Зөвлөмж хүргүүлэх	ХСИС-ийн захирал, Ерөнхий нягтлан бодогч	Ө.Энхтөр, Ц.Мөнгөнцэцэг
4	ТӨБЗГ-ын шийдвэр гарч бүртгэлд шилжин ирээгүй автомашиныг өөрийн хэрэгцээнд ашиглаж байна.	-	Зөвлөмж хүргүүлэх	ХСИС-ийн захирал, Ерөнхий нягтлан бодогч	Ө.Энхтөр, Ц.Мөнгөнцэцэг
Дүн		564,892.8			